

КОМПЛАЙНС

Комплайнс гэдэг нь байгууллагын дотооддоо мөрдөж буй бодлого, төлөвлөгөө, дүрэм, журам, үйл ажиллагааны горим болон практик дадал зэрэгт тавигддаг шаардлагуудыг бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн нийгмийн үнэт зүйлстэй уялдан зохицуулах засаглалын хэрэгсэл юм.

Энэхүү хэрэгслийг амьдралд нутагшуулах гэдэгт тухайн байгууллагыг төлөөлж буй ажилтан өөрийн тодорхой үйл ажиллагаагаа комплайнсын стандартуудад захирагдан үйлдэж байх нөхцөлийг бүрдүүлэх гэж ойлгож болно.

Манай орны хувьд аж ахуйн нэгжүүд өөрсдийн үйл ажиллагааг сайжруулах үүднээс сайн засаглал, нийгмийн хариуцлага, хүний нөөцийн болон эрсдэлийн удирдлага, дотоод хяналт зэрэг засаглалын олон хэрэгслүүдийг нэвтрүүлж эхлээд удаагүй бөгөөд комплайнс хэмээх тогтолцоо хөгжлийнхөө эхэн үедээ байна. Харин хөгжингүй орнуудын хувьд энэхүү тогтолцооны олон хэлбэрүүд бизнесийн бүх салбаруудад нэгэнт хэвшээд эхэлжээ.

Комплайнсыг хэрэгжүүлнэ гэдэгт эрх зүйн хэм хэмжээ ба байгууллагын дотоод комплайнс хяналтын стандартуудыг хэлбэрэлтгүй мөрдөх үйл явц, хууль бус үйлдэл, ёс зүйн зөрчлүүдийг зохих хяналтын бүтцэд мэдэгдэх бие даасан, байнгын ажиллагаатай удирдлагын тогтолцоо гэж ойлгож болно.

Комплайнсын тогтолцоонд дараах эрсдэлүүд хамаарч байна. Үүнд:

- Зохицуулалтын нөхцөл, шаардлагын хүрээнд учирч буй зөрчил;
- Санхүүгийн хууль бус үйлдэл;
- Албан тушаалаа урвуулан ашиглах, эсхүл авлигын үйлдэл;
- Албан хаагчдын мэргэжлийн бус үйлдэл;
- Гадна талаас учирч болох хууль бус үйлдэл;
- Бизнесийн нэр хүнд унах, санхүүгийн чадамжгүй болох эрсдэл.

Дээр дурдсан эрсдэлээс дараах хор хохирол учирч болно. Үүнд:

- Материаллаг;
- Цаг хугацааны;
- Үнийн дүн бүхий;
- Оюуны өмчийн;
- Мэдээллийн;
- Хөдөлмөрийн хүчний;
- Бусад хохирол (хүний амь нас, эрүүл мэнд, байгаль, экологи, байгууллагын нэр хүндэд учрах хор хохирол).

Зарим байгууллагууд дотоод хяналт болон комплайнс нь бизнес эрхлэхэд төдийлөн ач холбогдолгүй гэж үзээд тэдгээрт цаг хугацаа, хөрөнгө оруулах сонирхолгүй байдаг бол зарим компанийн жишээн дээр чанартай комплайнс хяналт нь байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлдгийг практик дээр харуулсаар байна. Энэ нь үйлчлүүлэгчдийн эерэг хандлага, зан төлөв, хөрөнгө оруулагчдын сонирхол, хувьцаа эзэмшигчдийн компанид итгэх итгэл, нийгмийн хандлага зэргээр илэрхийлэгддэг.

Тухайлбал, олон улсын хөрөнгийн зах зээлд үнэт цаасаа санал болгож буй компанийн хувьд тэрээр өөрийн комплайнс тогтолцоотой байх нь тухайн орны зохицуулагч

байгууллага болон мэргэжлийн институционал хөрөнгө оруулагчдын зүгээс нааштай эерэг үнэлгээ өгөх суурь нь болдог.

Мөн үр дүн бүхий комплайнс хяналтын тогтолцоо нь хөрөнгө оруулах сонирхол, санхүүгийн болоод үйл ажиллагааны найдвартай байдлын түвшинг дээшлүүлдэг байна. Нөгөө талаас АНУ (Foreign Corrupt Practices Act 1977), ИБУИВУ (UK Bribery Act 2010) зэрэг орнуудын хууль эрх зүйн орчин нь гадаадын компани өөртөө үр дүн бүхий комплайнсын нэгжтэй байхыг чухалчлан шаарддаг.

Одоогоор манай улсын хувьд хөрөнгийн зах зээл, даатгалын салбарын оролцогчид болон гадаадын зах зээлд түшиглэн үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд нь комплайнсын хяналтыг эхний ээлжинд нэвтрүүлэх зорилтот бүлгүүд болоод байна.

Нөгөө талаас комплайнсын хяналтыг нэвтрүүлэх нь тухайн байгууллагын хэмжээ, үйл ажиллагааны далайцаас огт хамааралгүй юм. Учир нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх болон авлигын эсрэг эрх зүйн орчин болон комплайнсын стандартуудыг зах зээлд оролцогч бүх талууд мөрдөх үүрэгтэй.

Байгууллагын хийж буй хэлцэл бүрийг комплайнсын хяналтаар шалгаж болох энэ тогтолцоо нь удаан хугацаанд амжилттай явах итгэл найдварыг бизнес эрхлэгчдэд бий болгодог байна.

Харин комплайнсын хяналттай холбоотойгоор дараах эрсдэлүүд бизнесийн байгууллагад үүсч болно:

- Гүйлгээний данс хаагдах, царцах;
- Төлөвлөгөөт бус газар дээрх хяналт шалгалт хийгдэх;
- Захиргааны арга хэмжээ, торгууль тавигдах;
- Үйл ажиллагаа нь хэсэгчлэн, эсхүл бүрэн зогсох;
- Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэл нь түдгэлзэх, цуцлагдах
- Төлбөрийн чадваргүй болох;
- Нэр хүнд нь унаснаар бусдаас хөрөнгө татах түвшин нь буурах.

Комплайнсын хяналтын чиг үүргийн үндсэн зарчмууд

1. Хараат бус байдал. Энэхүү зарчим нь өөр хоорондоо харилцан нягт уялдаатай 4 комплайнсын хэсгээс бүрддэг байна.

- Комплайнсын хяналтын үйл ажиллагаа нь албан ёсны бие даасан байх;
- Комплайнсын эрсдэлийн удирдлагын уялдааг хангах комплайнсын мэргэжилтэнтэй байх;
- Комплайнсын хяналтыг хэрэгжүүлэх болон компанийн ажилтнуудын хооронд сонирхлын зөрчил үүсгэхгүй байх;
- Комплайнсын хяналтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүү, төсөвтэй байх ба комплайнсын мэргэжилтэн нь байгууллагын бүх нэгжүүдээс шаардлагатай мэдээллийг авах эрх нь нээлттэй байх.

2. Эрх зүйн байдал. Комплайнсын хяналтыг зохицуулж буй норматив, стандартуудыг байгууллагын дотоод дүрэм, журамд тусгах ба дараах нөхцөлүүдийг багтаасан байна:

- Комплайнсын хяналтын зорилго, чиг үүрэг ба комплайнсын мэргэжилтний үүрэг хариуцлага;
- Комплайнсын хяналтын хараат бус байдлыг хангасан нөхцөлүүд;
- Эрсдэлийг хянах чиглэлээр комплайнсын хяналтын нэгжийн байгууллагын бусад нэгжүүд, дотоод хяналтын нэгжтэй хамтран ажиллах аргачлал;

- Комплайнсын мэргэжилтний шаардлагатай гэж үзсэн мэдээллийг авах эрх, мөн бусад ажилтнуудын түүнд мэдээлэл өгөх үүрэг, хариуцлага;
- Комплайнсын норматив, стандартыг зөрчсөнтэй холбоотойгоор дотоод шалгалт хэрэгжүүлэх эрх;
- Комплайнсын мэргэжилтний компанийн удирдлага /ТУЗ, ТУЗ-ийн хороод, гүйцэтгэх удирдлага/-д мэдээлэл өгөх, санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх;
- Комплайнсын чиглэлээр компанийн эрх бүхий этгээдийн тайлагналд хяналт тавих эрх;
- ТУЗ болон түүний хороодтой шууд харьцах эрх.

3. Комплайнсын мэргэжилтний тайлагнал. Компанийн салбар, нэгжид хамаарах комплайнсын мэргэжилтэн өөрийн шууд удирдлагадаа тайлагнах бөгөөд комплайнсын чиглэлээр компанийн комплайнсын хяналтын удирдах ажилтанд мөн тайлагнана.

4. Сонирхлын зөрчлийг арилгах. Комплайнсын мэргэжилтний хараат бус байдал нь түүний байгууллагад ажиллаж буй ердийн албан тушаалаар хүлээсэн үүрэг, хариуцлагатай сонирхлын зөрчил үүсгэснээр алдагдаж болно. Мэдээж комплайнсын ажилтан нь зөвхөн комплайнсын хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх нь зохистой боловч ихэвчлэн жижиг компаниудын хувьд энэ нь боломжгүй тул давхар чиг үүрэг хүлээдэг тул энэ нөхцөлд сонирхлын зөрчлийг үүсгэж болох нөхцөлийг арилгах нь маш чухал. Учир нь комплайнсын хяналтыг хэрэгжүүлж байгаа байгууллага, тухайн бүтцийн нэгжийн үйл ажиллагааны үр дүнгээс комплайнсын ажилтны шагнал, урамшуулал шууд хамаарах боломжтой.

5. Дотоод мэдээллийн нээлттэй байдал. Комплайнсын хяналтын алба нь өөрийн санаачилгын дагуу байгууллагын бүх нэгжийн албан хаагчидтай хамтран ажиллаж, комплайнсын чиглэлээр дурын мэдээллийг авах эрхтэй.

6. Нөөц. Комплайнсын хяналтын үйл ажиллагааны нөөц нь зохих хэмжээнд хангагдсан байх шаардлагатай. Комплайнсын хяналтын үйл ажиллагааны нэг чухал нөөц бол мэргэшсэн, туршлага, мөн хувийн зан чанар бүхий хүний нөөц юм. Мэргэжилтнүүд нь байгууллагын зүгээс хууль тогтоомж, эрх зүйн акт, нормативыг мөрдөх, тэдгээрийн үр нөлөө, ач холбогдлын талаар мэргэшсэн байна. Хяналтын арга барил, хууль тогтоомжийн шинэчлэл, өөрчлөлт зэргийг сургалт, дадлагын тусламжтайгаар мэргэшүүлнэ.

7. Зохицуулагч болон хяналтын байгууллагатай хамтран ажиллах. Комплайнсын хяналтын ажилтнуудын хяналтын байгууллагуудтай харилцан үр дүнтэйгээр хамтран ажиллах явдал маш чухал.

Энэ тал дээр дараах хүндрэлүүд үүсч болно:

- Хяналтын байгууллагаас шаардсан баримт, тайлан мэдээг бүрэн хэмжээгээр боловсруулан хүргэх нь хугацаа шаардсан үйл явц ба хэрэв үүнийг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд асуудал үүснэ;
- Маргаантай асуудлаар хамтарсан уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулах шаардлагатай ба энэ нь харилцааны чадвар, туршлага шаарддаг, зарим тохиолдолд нэмэлт нөөцийн хэрэгцээг үүсгэдэг;
- Хяналтын байгууллагаас зөрчил илрүүлсэн тохиолдолд нөхцөл байдлыг дүгнэж, шийдвэр гаргах ур чадвар шаардагддаг. Ийм тохиолдолд хяналтын байгууллагатай хамтран ажиллах нь үйл ажиллагаагаа хэвийн үр дүнтэй явуулах суурь нь болдог байна.

ДОТООД ХЯНАЛТ БА КОМПЛАЙНСЫН ЯЛГАА

Дээр дурдагдсан комплайнсын хяналтын чиг үүргүүдийг харахад санхүүгийн байгууллагуудын дотоод хяналттай ижил байдал ажиглагддаг. Гэсэн хэдий ч Базелийн хорооны зөвлөмжид комплайнсын хяналт болон дотоод хяналтын чиг үүргүүдийг тусгаарлах, комплайнсын хяналтын үйл ажиллагааг тодорхой цаг хугацааны үечилсэн байдлаар үнэлж байхыг онцолсон байна.

Мэдээж хараат бус бие даасан үнэлгээг хийх болон комплайнсын эрсдэлийг тогтоох, удирдах аргачлалыг нэгэн зэрэг хэрэгжүүлэх нь боломжгүй бөгөөд энэ салбарын мэргэжилтнүүдийн зүгээс эрсдэлийг удирдах комплайнсын хяналт болон дотоод аудитын өмнөх зорилтууд өөр өөр байдаг гэсэн дүгнэлтэд хүрчээ.

Дотоод аудитын зорилтууд нь комплайнсын хяналтын үйл ажиллагаанаас илүү өргөн утгыг хамрах ба өөртөө бүртгэл, тайлагналын үнэн зөв байдлын хяналт, гүйцэтгэлийн үр дүн, мөн байгууллагын стратегийн зорилгуудыг хэрэгжүүлэх зэргийг багтаадаг.

Дан ганц дотоод аудит үйл ажиллагаа явуулах тохиолдолд өөр өөр чиг үүргүүд нэгтгэгдсэнээр сонирхлын зөрчлийн эрсдэлийг үүсгэх ба эрсдэлийг удирдах болон дотоод хяналтын зарчмуудад харшлах болно.

Өөрөөр хэлбэл, дотоод аудитын чиг үүрэг бол дотоод хяналтын системийн хараат бус бие даасан шалгалт, харин байгууллагын комплайнсын эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаанд тавих байнгын хяналтыг комплайнсын хяналтын тогтолцоо хэрэгжүүлдэг байна.

Нөгөө нэг чухал ялгаа нь цаг хугацааны хүчин зүйлд оршдог. Эрсдэлийг удирдах үүрэг бүхий комплайнс хяналт нь байгууллагын бүх шатанд буй комплайнс эрсдэлийг тооцон уялдуулснаар цаг хугацааны хувьд урьдчилсан төлөвт ажилладаг бол аудиторуд нэгэнт болоод өнгөрсөн үйл явдал болон тухайн цаг үед нөхцөл шаардлагыг хангаж буй эсэхэд анализ хийдэг байна.

Үүнээс үзэхэд, хэдийгээр чиг үүргийн хувьд ойр, төстэй боловч дотоод аудит болон комплайнсын хяналтын үйл ажиллагааг нэг нэгжээр гүйцэтгүүлэх нь зохимжгүй юм.

Комплайнсын хяналтаар хэрэгжүүлэх үндсэн бодлогын баримтууд

Комплайнсын хяналтын системийн загварчилсан багц бодлогын баримтууд нь янз бүрийн байгууллагуудад газар зүйн байрлал, үйл ажиллагааны онцлог зэргээс хамаарахгүйгээр ашиглагдаж байна.

— **Ёс зүйн кодекс**, Үүгээр ажилтнуудын ёс зүй, биеэ авч явах хэм хэмжээ, мөн тэдгээрийн үүрэг хариуцлага зэрэг комплайнсын үндсэн хандлага, зарчмуудыг тусгасан байдаг.

— **Мөнгө угаахтай тэмцэх**, Энэ нь хууль бус орлогыг санхүүгийн салбарт оруулан угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх зорилго бүхий олон улсын эрх зүйн хэм хэмжээнд тусгагдсан бодлого юм.

— **Бэлэг хүлээн авах, бэлэглэх**, Бэлэг, авлига, албан тушаалаа урвуулан ашиглаж ашиг олох зэргийн хооронд нарийвчилсан хязгаарыг тогтоох ба комплайнсын хяналтын үүрэг нь бэлгийг бүхэлд нь хориг тавих бус, түүний үнэ өртөгт хязгаарлалт хийх, бэлэглэх, бэлэг хүлээн авах үйл явцыг дотоод журмын хүрээнд зохицуулахад оршино.

— **Ёс зүйн хэм хэмжээ зөрчсөнийг мэдээлэх**, Ажилтнуудын гаргасан ёс зүйн зөрчлийн талаар мэдээлэл авах, мэдээлэгчийн нууцлалыг хадгалах, улмаар шалгалт хийх, баримтжуулах зэргийг зохицуулах ба байгууллагын дотоодод буй ёс зүйн зөрчлийн эсрэг үйлчилдэг.

— **Сонирхлын зөрчлийг зохицуулах**, Сонирхлын зөрчил үүссэн тохиолдолд байгууллагын ажилтнуудын авч хэрэгжүүлэх ёс зүйн арга хэмжээний аргачлал (ажилтан болон байгууллагын хооронд, үйлчлүүлэгчдийн хооронд гэх мэт). Ажилтны зүгээс сонирхлын зөрчлийг илрүүлэх, түүнд тавигдаж буй хяналт, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд идэвхтэй оролцохыг үүрэгжүүлж өгдөг. Комплайнсын хяналтаар байгууллагын ашиг сонирхол нь ажилтны хувийн сонирхлоос дээш тавигдана гэж үздэг байна.

— **Ажилтан үнэт цаас худалдан авах**, Санхүүгийн байгууллагын мэргэжилтнүүд үнэт цаасны зах зээлд оролцох үедээ хэрэгжүүлэх хэм хэмжээг тогтоодог ба ерөнхийдөө хамаарал бүхий этгээдийн үнэт цаасыг худалдан авах, богино позицоор хэлцэл хийхийг хориглох гэх мэт зарим хязгаарлалтыг оруулдаг байна. Энэхүү комплайнс хяналтын бодлого нь тухайн ажилтан албаны мэдээлэл болон цагийг зүй бусаар буюу хувийн ашиг сонирхлын төлөө ашиглах, мөн үнэт цаасны зах зээлийн хувьд тухайн мэргэжилтнийг ёс зүйгүй үйлдэл хийсэн гэж буруутгахаас сэргийлэхийн тулд хэрэгжүүлдэг.

— **Цагаан хэрэм**, Мэдээллийн хана нь дотоод мэдээллийн нууцлалыг хангах зорилготой бөгөөд энэ нь сонирхлын зөрчил үүсэхээс сэргийлж, шударга өрсөлдөөнийг дэмждэг. Ялангуяа хөрөнгө оруулалтын байгууллагууд үүнийг чухалчлан авч хэрэгжүүлдэг байна.

— **Мэдээллийн нууцлал**, Үүгээр харилцагч болон түүний хэлцлийн талаарх мэдээллийг нууцлах хяналтыг бий болгодог. Өөрөөр хэлбэл, харилцагчийн мэдээлэлтэй ажиллах, хамгаалах үйл явцыг комплайнс стандартуудын дагуу хэрэгжүүлэх нөхцөлийг үүсгэх юм.

Мөн өргөдөл гомдлын, ажилтнуудыг мэргэшүүлэх гэх мэт бусад комплайнсын хяналтууд байдаг ба тухайн байгууллагын зорилгоос хамаарч тусгайлсан өөр өөр төрлийн бодлогыг хэрэгжүүлэх замаар өөрийн гэсэн комплайнс системийг бий болгох боломжтой.

Аль ч оронд аж ахуй эрхлэхэд хөдөлмөрийн харилцаа, тухайн салбарын зохицуулалтууд, харилцагчийн эрх, татвар, техникийн стандартууд гэх мэт олон төрлийн эрх зүйн актууд үйлчилдэг ба тэдгээр нь тогтмол шинэчлэгдэж байна.

Эрх зүйн шинэчлэлийг тухай бүр мэдэж байхын зэрэгцээ өөр өөр нөхцөл байдалд ажилтнуудын дагаж мөрдөх үйл хөдлөлийн стандартуудыг боловсруулж, тэдгээрийг мэргэшүүлэх, мэдлэг мэдээллийг нь тогтмол зохист хэмжээнд байлгахын тулд сургалтыг зохион байгуулах нь чухал. Мөн гарсан зөрчлийн учир шалтгааныг тодорхойлж, цаашид гаргахгүй байх тал дээр нь зохицуулалт хийж байх нь зөв.

Тэгэхээр нэгэн олон улсын хэмжээний компанийн жишээн дээр эрсдэлийн удирдлагын талаар авч үзье. Тус компани зөрчлийн дахин давтагдах нөхцөлийг хамгийн бага түвшинд хүргэх үүднээс комплайнсын хяналтын системийг 3 түвшинд хуваасан байна:

Урьдчилан сэргийлэх	Илрүүлэх	Хариу үйлдэл үзүүлэх
Комплайнс эрсдэлийг илрүүлэх, үнэлэх	Мэдээлэл хүлээн авах суваг /утас болон цахимаар/	Алдаанаас дүгнэлт гаргах
Бодлого болон дотоод дүрэм, журмыг	Комплайнс хяналт	Сайжруулалт хийх

боловсруулах		
Сургалт болон харилцаа	Түнш болон бэлтгэн нийлүүлэгчдэд мониторинг, шалгалт хийх	Мөрдөн шалгах
Зөвлөгөө болон дэмжлэг үзүүлэх	Комплайнс-аудит	
Нэгдмэл болон тухайн үйл явцын	Комплайнс туршилтууд	
Багийн хамтарсан ажиллагаа		

Комплайнс хяналтын бодлогоо хэрэгжүүлэхийн тулд тус компани бүх нэгжүүддээ мөрдүүлэхээр дотоод дүрэм, журам боловсруулсан байна:

1. Компанийн ажлын байран дахь үйл хөдлөлийн аргачлал;
2. Үйл хөдлөлийн кодекс гэх мэт.

Тус компани өөрийн цахим хуудсандаа жилийн санхүүгийн болон санхүүгийн бус мэдээ, тайланг тайлагнадаг ба зөрчлийн талаарх мэдээллийг ч олон нийтийн хүртээл болгодог байна.